

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл .Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын тусгай болон бусад чиг үүргийг тогтоох, хөгжлийн бодлого, удирдлага, зохион байгуулалтын онцлог, дагуул хот, эдийн засгийн тусгай бүс, төрийн дээд болон төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, хуулийн этгээд, байгууллагатай харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдалтай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

##### 4 дүгээр зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн үндэс, зохион байгуулалт

4.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот /цаашид "нийслэл хот" гэх/ нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалттай эрх зүйн байдал бүхий хот мөн.

4.2.Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.

4.3.Нийслэл хот нь дагуул хоттой байна.

##### 5 дугаар зүйл.Нийслэл хотыг хөгжүүлэх бодлого

5.1.Нийслэл хотыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаас гадна нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарчмыг баримтална.

5.2.Нийслэл хотын хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого нь үндэсний уран барилгын өв уламжлалыг орчин үеийн хотын хөгжлийн нийтлэг жишигтэй хослуулан хөгжүүлэхэд чиглэнэ.

5.3.Нийслэл хот нь нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийн хүрээнд газар чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт жил бүр тусгана.

##### 6 дугаар зүйл.Нийслэлийн нутаг дэвсгэр болон нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэл

6.1.Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байна.

6.2.Нийслэл хот нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан тэг гортиг бүхий эдэлбэр газартай байна.

6.3.Энэ хуулийн 6.2-т заасан эдэлбэр газар нь бүсчлэлтэй байх бөгөөд эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Засгийн газар тогтооно.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

6.5.Хотын төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэмд заасан хүн амын нягтралын хязгаарыг давсан газарт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй.

## **7 дугаар зүйл.Бэлгэ тэмдэг**

7.1.Нийслэл хот бэлгэ тэмдэгтэй байна.

7.2.Нийслэл хотын бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **НИЙСЛЭЛ ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, ДҮРЭМ**

#### **8 дугаар зүйл.Нийслэл хотын чиг үүрэг**

8.1.Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1-д зааснаас гадна нийслэл хот болохын хувьд энэ хуульд заасан тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.2.Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн ўйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх;

8.2.2.хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах;

8.2.3.олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн ўйл ажиллагааны удирдлага, зохицуулалт;

8.2.4.нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт;

8.2.5.нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүний арчлалт, засвар, холбогдох ўйл ажиллагаа;

8.2.6.нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт;

8.2.7.энэ хуульд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, авто зам, нийтийн эзэмшийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт.

8.3.Нийслэл хот нь дараах бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.3.1.нийслэлийг хөгжүүлэх сангийн менежмент;

8.3.2.нийслэлийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт;

8.3.3.орчны аюулгүй байдал;

8.3.4.хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;

8.3.5.хот, суурин газрын дахин төлөвлөлт;

8.3.6.нийслэлийн авто замын арчлалт, засвар, төлөвлөлт, хяналт;

8.3.7.хүн амын ундын болон ахуйн хэрэглээний төвлөрсөн усан хангамж;

8.3.8.нийслэлийн ус, дулааны төвлөрсөн бус инженерийн хангамж;

8.3.9.сууц өмчлөгчдийн холбооны ўйл ажиллагааны зохицуулалт, хяналт;

8.3.10.гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;

8.3.11.авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;

8.3.12.гадаадын зээл, тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нийслэлийн хариуцах хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөр;

8.3.13.нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт;

8.3.14.нийслэлийн нутаг дэвсгэр дэх дархан цаазат болон байгалийн цогцолбор, нөөц, дурсгалт газрыг иргэдийн аялах, амрах орчныг бүрдүүлэх зорилгоор тохижуулах, хамгаалах төсөл, арга хэмжээ;

8.3.15.хотын өөрийн мэдлийн орон сууцны ашиглалт, хуваарилалт;

8.3.16.хуульд заасан бусад.

8.4.Засгийн газар энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн өмчийг эзэмших, ашиглах эрхийг хууль тогтоомжид нийцүүлэн нийслэлд шилжүүлж болно.

9.1.Хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг нийслэл хотын дүрмээр зохицуулж болно.

9.2.Нийслэл хотын дүрмийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

9.3.Нийслэл хотын дүрмийг олон нийтэд тайлбарлан таниулсны үндсэн дээр Захиргааны өрөнхий хуулийн 67.2-т заасны дагуу бүртгүүлснээс хойш гурваас доошгүй сарын дараа дагаж мөрдүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### НИЙСЛЭЛ ХОТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

#### 10 дугаар зүйл.Нийслэл хотын эдийн засгийн үндэс

10.1.Нийслэл хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн нийслэлийн өмч, татварын болон татварын бус орлого, нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс бүрдэнэ.

10.2.Нийслэл хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах нь төрийн үүрэг бөгөөд энэ харилцаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.1-д заасны дагуу бие даасан төсөвтэй байна.

#### 11 дүгээр зүйл.Нийслэлийн төсөв

11.1.Нийслэл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.1-д заасны дагуу бие даасан төсөвтэй байна.

11.2.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

#### 12 дугаар зүйл.Нийслэлийн өмч

12.1.Нийслэл өмчтэй байна.

12.2.Нийслэлийн өмч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1 дэх хэсэг, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд зорилгоор хуульд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах хөрөнгө болно.

12.3.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн өмчийн өмчлөх эрхийг хууль тогтоомжид заасны дагуу нийслэлд шилжүүлж болно.

#### 13 дугаар зүйл.Нийслэлийн үнэт цаас

13.1.Нийслэл хуульд заасан нөхцөл, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.

13.2.Нийслэлийн үнэт цаас гаргах асуудлыг Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

#### 14 дүгээр зүйл.Концесс олгох

14.1.Нийслэлд концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Концессын тухай хуулийн дагуу зохицуулна.

#### 15 дугаар зүйл.Нийслэлийн өмчит хуулийн этгээд

15.1.Нийслэл нь орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй байж болно.

15.2.Нийслэлийн болон нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хувийн өмчийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй ажил үйлчилгээг энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

#### 16 дугаар зүйл.Нийслэл хотын албан татвар

16.1.Нийслэл хот албан татвартай байх бөгөөд албан татварыг хуулиар тогтооно.

16.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь татварын хууль тогтоомжоор эрх олгож, тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно.

#### 17 дугаар зүйл.Нийслэлийг хөгжүүлэх сан

17.1.Нийслэл нь нийслэлийг хөгжүүлэх сантай байж болно. Нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

17.1.1.хотын стандарт, соёлыг хөгжүүлэх;

17.1.2.ухаалаг, цахим хотын хөгжлийг дэмжих;

17.1.3.үйлдвэрлэл, инновацыг дэмжих;

- 17.1.4.хөрөнгө оруулалтыг дэмжих;
- 17.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;
- 17.1.6.хот байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх;
- 17.1.7.ногоон хөгжлийг дэмжих;
- 17.1.8.аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- 17.1.9.эрсдэлийг бууруулах.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгө нь нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

17.4.Нийслэлийг хөгжүүлэх сангаас зээл олгох, өр, авлага үүсгэхийг хориглоно.

## **18 дугаар зүйл.Нийслэл хот дахь хөрөнгө оруулалт**

18.1.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.2-т заасан этгээд нийслэлийн өмчит ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хөрөнгөд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж болно.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасны дагуу ирүүлсэн хөрөнгө оруулалт хийх саналыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ.

## **19 дүгээр зүйл.Нийслэл хот дахь хөрөнгө оруулалтыг дэмжих**

19.1.Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллаж нийслэл хотыг хөгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэргэд байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан зөвлөл нь орон тооны бус байх ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

19.3.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 18.2-т заасны дагуу хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчийг дараах баталгаагаар хангана:

19.3.1.энэ хуулийн 18.2-т заасан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, цуцлах асуудлыг шийдвэрлэхдээ Захиргааны өрөнхий хуульд заасан журам, үндэслэлийг баримтлах;

19.3.2.хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллээр хангах;

19.3.3.хуульд өөрөөр заагаагүй бол газар эзэмшигүүлж, ашиглуулах шийдвэрээ өөрчлөхгүй байх;

19.3.4.хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаанд хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох;

19.3.5.хуульд заасан бусад.

19.4.Нийслэл хотын удирдлага хуульд өөрөөр заагаагүй бол нийслэл хот дахь хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй байлгах үүднээс энэ хуулийн 18.1-д заасан хөрөнгө оруулалт авсан хуулийн этгээдийг дараах баталгаагаар хангана:

19.4.1.ажиллах цагийн хуваарийг уян хатан шийдвэрлэх;

19.4.2.нийтийн ашиг сонирхлын үүднээс хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, зорилгоос хамаарч холбогдох журамд заасан зардлын санхүүжилтийг олгох;

19.4.3.хуульд заасан бусад.

19.5.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 19.3, 19.4-т заасан баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэхдээ Захиргааны өрөнхий хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгох боломжийг хэрэглэнэ.

19.6.Нийслэл хот дахь хөрөнгө оруулагчийг энэ хуулийн 19.3, 19.4-т заасан баталгаагаар хангах эсэхийг сонгоходоо нийслэл хотын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг шалгуур болгож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **НИЙСЛЭЛ ХОТЫН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ**

## **20 дугаар зүйл.Нийслэл хотын удирдлага, түүний онцлог**

20.1.Нийслэл хотын удирдлага дараах тогтолцоотой байна:

20.1.1.нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

20.1.2.нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч.

20.2. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатархотын Захирагч байх бөгөөд ажлын албатай байна.

20.3. Нийслэл хотын удирдлага шийдвэр гаргахдаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийг баримтална.

20.4. Засгийн газар нийслэл, дүүргийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг нутгийн захиргааны бусад адилтгах албан тушаалын ангилал зэрэглэлээс өөрөөр тогтоож болно.

## **21 дүгээр зүйл. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

21.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийн хэрэгжилтийн талаарх нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн тайланг сонсох;

21.1.2. Энэ хуулийн 8.3-т заасан бусад чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хэрэгжилтийн талаарх нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн тайланг дүгнэх;

21.1.3. Нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах;

21.1.4. Нийслэл хотын болон нийтийн эдэлбэр газар, түүний хэмжээ, ашиглалтын журмыг тогтоох;

21.1.5. Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

21.1.6. Хуульд заасан бусад.

## **22 дугаар зүйл. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрх**

22.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

22.1.2. Энэ хуулийн 8.3-т заасан бусад чиг үүрэгтэй холбогдох тооцоо, судалгаа бүхий шийдвэрийн төсөл боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

22.1.3. Энэ хуулийн 22.1.2-т заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг хариуцах;

22.1.4. Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Засгийн газарт санал тавих, Засгийн газрын хуралдаанд оролцох;

22.1.5. Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хуулийн төсөл санаачлахаас бусад асуудлаар Засгийн газрын шийдвэрийн төслийг холбогдох журмын дагуу санаачлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж, танилцуулах, хэлэлцүүлэх;

22.1.6. Нийслэл хотыг хөгжүүлэх асуудлаар төсөл, хөтөлбөр санаачлах, төсөл, хөтөлбөрт санал, дүгнэлт өгөх, тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;

22.1.7. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулснаар нийслэл хотын дагуул хотын Захирагчийг томилох, чөлөөлөх;

22.1.8. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх;

22.1.9. Дотоод, гадаадад нийслэлийг төлөөлөх;

22.1.10. Гадаад улсад нийслэл хотыг төлөөлөх этгээдийг томилох, чөлөөлөх;

22.1.11. Зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

22.1.12. Улаанбаатар хотын Ерөнхий менежерт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ шилжүүлэх;

22.1.13. Хуульд заасан бусад.

22.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1.7, 24.1.9, 24.1.10, 24.1.11, 24.1.12, 24.1.13, 24.1.14, 24.1.15, 24.1.16, 24.1.17, 24.1.18, 24.1.19, 24.1.21, 24.1.22, энэ хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6, 8.3.7, 8.3.8, 8.3.9, 8.3.10, 8.3.11, 8.3.12-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ Улаанбаатар хотын Ерөнхий менежерт гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.

22.3. Энэ хуулийн 22.2-т заасан гэрээнд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатархотын Захирагчаасшилжүүлэх бүрэн эрхийн хүрээ, хязгаар, тайлгахаа, хяналт тавих журмыг тусгана.

22.4. Энэ хуулийн 22.2-т заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлсэн нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын